

Блог вэб сайт хийх заавар 2

- Сайтаа яаж засах, мэдээлэл нэмэх вэ?

Нэгэнт бүртгүүлсэн блог вэб сайтаа засах, мэдээлэл нэмэхийн тулд эхлээд сайтдаа нэвтрэх шаардлагатай. Үүний тулд, <http://ТАНЫ-бүртгүүлсэн-нэр.tbb.mn/wp-login.php> хаягаар орох. (Хэрвээ arigsor.mn -нд бүртгүүлсэн бол: <http://ТАНЫ-бүртгүүлсэн-нэр.arigsor.mn/wp-login.php>, Co-ltd.mn -нд бүртгүүлсэн бол: <http://ТАНЫ-бүртгүүлсэн-нэр.co-ltd.mn/wp-login.php> -ээр орох).

Жишээ нь, <http://demo1.tbb.mn/wp-login.php>



Хэрэглэгчийн нэр гэсэн цонхонд бүртгүүлсэн хэрэглэгчийн нэрээ бичиж өгөөд нууц үгээ оруулаад НЭВТРЭХ гэсэн товчийг дарах. Жишээ нь: demo1



Хэрвээ нууц үгээ мартсан бол “Lost your password” гэсэн холбоосыг дараад бүртгүүлсэн email-ээ оруулаад GET NEW PASSWORD товчийг дарах.

Бүх мэдээллийг зөв оруулсан бол дараах цонх гарч ирнэ.

WordPress Dashboard for Demo1.TBB.mn. The interface is in Mongolian. The left sidebar contains navigation menus: "Ерөнхий мэдээлэл - Dashboard", "Ерөнхий мэдээлэл - Dashboard", "Мэдээ оруулах - Posts", "Файлууд - Media", "Линкүүд - Links", "Хуудсууд - Pages", "Сэтгэгдэл - Comments", "Сайтын харагдах байдал - Appearance" (circled in red), "Plugins", "Хэрэглэгчид - Users", "Хэрэгсэл - Tools", and "Тохруулга - Settings". The main dashboard area includes sections for "Right Now" (At a Glance), "QuickPress", "Recent Comments", "Incoming Links", "Recent Drafts", and "WordPress Development Blog". The "Right Now" section shows 1 Post, 1 Page, 1 Category, 0 Tags, 1 Comment, 1 Approved, 0 Pending, and 0 Spam. The "Storage Space" section shows 100MB Space Allowed and 0MB (0%) Space Used. The "Recent Comments" section shows a comment from "Mr WordPress on Hello world! #". The "Incoming Links" section shows no incoming links. The "Recent Drafts" section shows no drafts. The "WordPress Development Blog" section shows two recent posts: "WordPress 3.0, Beta 2" and "WordCamp San Francisco 2010".

Энэ цонхны зүүн гар талд байгаа цэсүүдийг ашиглан сайтаа засварлах, мэдээ нэмнэ.

1. Эхлээд сайтын загварыг өөрчилье. Үүний тулд "Сайтын харагдах байдал" гэсэн цэсийг дарахад дараах цонх гарч ирнэ.

WordPress dashboard screenshot showing the 'Manage Themes' section. The 'Visit Site' button is circled in red. The 'Available Themes' section shows two themes: 'arigsor_wptheme1 1.0 by ArigSor.mn' and 'arigsor_wptheme2 1.0 by ArigSor.mn'. The 'Activate' button for the second theme is circled in red. The left sidebar menu is also visible, with 'Сайтын харагдах байдал - Appearance' circled in red.

Эндээс дурын загварыг сонгоод ACTIVATE гэсэн товчийг дарах. Жишээ нь: arigsor_wptheme2 –ийг сонгохын тулд түүний доор байгаа ACTIVATE товчийг даръя. Үүний дараа энэ цонхны зүүн дээд өнцөгт байгаа “Visit Site” холбоосыг дараад сайтаа ямар загвартай болсныг харж болно.

Жишээ нь дараах сайтыг ашиглан зарим зүйлийг тайлбарлая.

Co-Ltd.mn
Сайтаа бүртгүүл – Get your blog

Get your Web (English) | Ийм шинэ сайт авах:

Get your Web (English) | Ийм шинэ сайт авах:

Сайтаа бүртгүүл

Таны-нэр.arigsor.mn – төлбөргүй
Таны-нэр.Co-Ltd.mn – 20000 төг/жилд (Эхний 1 сар төлбөргүй)

Сайтын загвар өөрчлөх:

arigsor_wptheme7

Вэб сайтаа бүртгүүлэхийн тулд ЭНД ДАР. Үүний дараа:

1. Нэрээ (username=ТАНАЙ-компаны-нэр) сонгоод email-ээ оруулах
2. Вэбийн дизайныг сонгох
3. Email-ээ шалгаад сайтаа идэвхжүүлнэ

Таны үүсгэсэн вэб сайт ийм хаягтай болно: таны-username.Co-Ltd.mn
Жишээ нь: www.arigsor.co-ltd.mn
Энэ үйлчилгээний үнэ: 1 жилд 20000 төгрөг. Эхний 1 сар төлбөргүй. (Хэрвээ төлбөргүй вэб сайт бүртгүүлэхийг хусвал эндээс авч болно: таны-нэр.arigsor.mn)
БҮРТГҮҮЛЭХ: ТАНАЙ-компаны-нэр.Co-Ltd.mn

Доор байгаа загваруудаас дүртайгаа сонгоод ашиглах болножтой.
ЗААВАР:

TOP.co-ltd.mn

Монголын шилдэг компанийдын жагсаалтанд үнэгүй бүртгүүл: Register free in Mongolian Top Companies Lists:
Mongolian TOP Companies List by arigsor.mn
Mongolian Top Sites by arigsor.mn

August 2010


M	T	W	T	F	S	S
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
	30	31				
< Mar						

- Сайтын дээд хэсгийг толгой (header) гэнэ. Үүнийг сольж болдог.
- Баруун, зүүн багананд байрлуулах “Календар” гэх мэт дурын тэкс, зураг гэх мэт хэсгүүдийг **Widget** гэнэ. Үүнийг одоохондоо орчуулаагүй байна. “Баганын мэдээ” гэж хэлж болох юм. Энэ талаар дэлгэрүүлэн доороос үзнэ үү.
- Төв хэсгийг сайтын үндсэн хэсэг гэнэ. Энд мэдээ, мэдээлэлээ оруулдаг.
- Ямар дизайн сонгосноос хамааран баруун, зүүн баганын байрлал өөр, өөр байна. Эсвэл аль нэг нь харагдахгүй.
- Сайтын хамгийн доод хэсгийг сайтын хөл (footer) гэнэ.
- Сайтын толгойн доод хэсэгт хэвтээ цэс (menu) байна. Үүнийг мөн баруун, зүүн баганын аль нэгэнд босоо байдлаар байрлуулж болдог. Цэсийг дэд цэсүүдээр задардаг хийж болно.



2. Сайтруу нэвтрэх нууц үгээ санахад хялбар өөр үгээр сольё.



Хэрэглэгчид гэсэн товчийг дарахад дараах цонх гарч ирнэ.



Хэрэглэгчийн нэр дээрээ дарахад дараах цонх гарч ирнэ.




Энэ цонхны хамгийн доор байгаа NEW PASSWORD гэсэн хэсэгт байгаа 2 цонхонд шинэ нууц үгээ бичээд Update Profile гэсэн товчийг даргах.


3. Сайтын зүүн, эсвэл баруун багананд мэдээлэл оруулах



Үүний тулд “Сайтын харагдах байдал” цэсний “Widgets” (Баганын мэдээ) гэсэн дэд цэсээр ороход дараах цонх гарч ирнэ. Энэ цонхны баруун гар талд SIDEBAR1 гэсэн нэрийн доор байгаа саарал зайнд зүүн талд байгаа Widgets-үүдээс дуртайгаа зөөж оруулахад энэ нь сайтын хажуу талын аль нэг багананд харагдах болно. Жишээ нь, Календар (Calendar) оруулъя. Үүний тулд Calendar гэсэн нэр дээр хулганаа аваачаад хулганыхаа товчийг дараастай хөдөлгөөд (зөөгөөд) SIDEBAR1-ийн доор аваачиж тавих.




Энэ амжилттай болбол дараах цонх гарна. Title гэсний доор “Календар” гэж бичээд SAVE товчийг дарвал таны сайтад Календар харагдах болно.



Энэ маягаар бусад Widgets-үүдийг аль нэг баганд байрлуулах боломжтой. Жишээ нь, шинээр жижиг мэдээ оруулъя гэвэл TEXT гэсэн Widgets-ийг оруулаад дурын текстээ бичээд SAVE товчийг дарах.

Мөн шинээр Widgets-үүдийг нэмж суулгах бололцоотой.


4. Сайтад мэдээ нэмэх



“Мэдээ оруулах” цэсээр ороод “Шинээр нэмэх” дэд цэсийг дар. Үүний дараа өмнө нь оруулсан мэдээг засах бол мэдээний нэр дээр дараад гарч ирсэн цонхонд засвар хийх. Шинээр мэдээ оруулах бол “Add New” гэсэн дарах.



Гарч ирэх цонхны дээд талын нүдэнд мэдээний гарчиг, доод хэсэгт мэдээний үндсэн хэсгийг бичээд PUBLISH товчийг дарах. **Монгол хэлээр** мэдээ бичихдээ UNICODE-үсгээр бичихээ битгий мартаарай. Энэ үсэг таны дэлгэцийн баруун гар талын доод өнцөгт байгаа.



Эдгээрийг мэдэж байхад блог вэб сайтаа чөлөөтэй хийх боломжтой. Илүү дэлгэрэнгүй зааврыг үргэлжлүүлэн гаргах болно.

Амжилт хүсье!

Email: info@arigsor.mn